

Лекц №11

ТРИЗ ба УРЛАГ


("Шинэ Хэвийн Байдал ба Урлагийн бүтээлч сэтгэлгээний туршлага"
хэлэлцүүлгийн бэлтгэл)
АГУУЛГА

1. Эргэн санах
2. ТРИЗ-ийг Урлагт хэрэглэх боломжуудыг эрэлхийлэх нь
3. XIX - XX зууны урлаг дахь ЭТШ- ийн жишээ

1. ЭРГЭН САНАХ

ТРИЗ анх техникийн систем, машин механизм, тоног төхөөрөмжийн дэвшлийн зүй тогтлыг судлах, тэдгээрийн үйл ажиллагааг сайжруулах, оновчтой шийдэл олох зохион бүтээх бүтээлч сэтгэлгээг хэрхэн хөгжүүлэх вэ? Ер нь бүтээлч сэтгэлгээнд сургаж болох уу? Эсвэл энэ нь хүнд авьяасын нэг адил анхнаасаа заяагддаг төрмөл зүйл үү? Хэрэв бүтээлч сэтгэлгээнд сургаж, бас суралцаж болдог бол ийм сургалтыг яаж явуулбал сайн үр дүн гарах вэ? Бүтэлгүй оролдлого, алдаж онох хохирол ихтэй замаар туршлага хуримтлуулж асуудлаа шийдсээр байх уу? Бүтээлчээр сэтгэж алдаагаа цөөлөх, оноогоо ахиулах, тэгснээрээ цаг хугацаа хожих, хөрөнгө зардал хэмнэх, үйл ажиллагааны бүтээмжийг дээшлүүлэх, эцэст нь *Бүтээгчийн аз жаргал* амсаж эдлэх ямар ямар боломж, нөөцүүд бидэнд байна? Зэрэг асуултуудын хариултуудын эрэл хайгуулаас эхэлсэн түүхтэй. Энэ тухай бид түрүүчийн хичээлүүдээр зарим нэг ойлголт авч, мэдлэгээ зузаалсан байх аа гэж найдна.

Общесистемные инструменты ТРИЗ



При решении задачи могут последовательно рассматриваться разные аспекты проблемной ситуации

2. ТРИЗ-ИЙГ УРЛАГТ ХЭРЭГЛЭХ БОЛОМЖУУДЫГ

ЭРЭЛХИЙЛЭХ НЬ

Энэ удаа ТРИЗ-ийг техникийн бус салбарт, тухайлбал урлаг соёлд ашиглах боломжуудын талаар жишээ баримттайгаар үзэцгээе. ТРИЗ-ийг бүхий л системийн хувьд хэрэглэх боломж байгааг, байхаар барахгүй бодит хэрэглээ нь амьдралд хэрэгжээд явж байгааг ТРИЗ-ийн онол, практикийг судалдаг судлаачид хэдий нь нотолсон байдаг. Жишээ нь, Латвийн ТРИЗ багш – коуч Ю.Мурашковскийн бүтээлүүд. Зарим шүүн тунгаагчид ТРИЗ нь урлаг судлал, урлагийн философид тод томруун дэвшил авч ирлээ, өнөөдөр эхлэл төдий байгаа энэ чиглэлд цаашид илүү их үр дүн гарна гэж дүгнэж байна.

Техник, бизнес, мэдээллийн ИТ салбар, соёл урлаг, нийгэм улс төрийн салбарууд бүгдийг системийн онол, арга аргачлалаар судалдаг гэвэл ТРИЗ-ийн арга хэрэгслүүдийг ашиглах боломжтой гэсэн үг юм.

Шинжлэх ухаан техник, урлаг соёл хоёр өөр өөрийн өвөрмөц зүй тогтол, хуулийн дагуу оршин тогтнож, хөгждөг болохоор цэвэр техникийн салбараас эхэлж онол практикийн цогц систем болон хэлбэржсэн ТРИЗ-ийг шууд л соёл урлагт авчраад “наачихаж” таарахгүй, наалдах ч үгүй, харин ч харилцааны асуудал, үл ойлголцол үүсэх эрсдэлтэй юм. Наад зах нь нэр томъёо, тодорхойлолт, ойлголт гээд цэгцэлж шийдэх олон асуудал бий. Эдгээр зүйлс бол суурь судалгаа шаардсан асуудлууд...

Харин өнөөдөр бид Урлаг, ТРИЗ хоёрын уулзвар, холбоос нь тов тодорхой тийм тохиолдлуудыг авч үзнэ ээ. Хэт нь Урлагт ч гэсэн асуудал шийдэх, бүтээлч бодлого бодох, Зохион Бүтээх арга аргачлал, алгоритм дүрэм өргөн дэлгэр хэрэгжинэ гэж найдна. Ингэснээр уран бүтээлчид маань урлагийн охин тэнгэр, онгод хийморийн од гэрлээс гадна Оюун ухааны мэргэн сургааль, хүчирхэг зэр зэмсэгтэй болж хүн зоноо сэтгэл оюуны гэгээрэл, ариусалд хүргэх болтугай! Бид урлагийн сод бүтээлүүд, тэдгээрийг бүтээгчдийн тухай урлагийн түүх, урлагийн философийн хичээлүүдээр зөндөө л үзсэн. Тэдгээр бүтээлч суутнууд маань урлагийн охин тэнгэр, онгод хийморийн од гэрлээс гадна оюун ухаан, бүтээлч сэтгэлгээгээ өндөр төвшинд хөгжүүлсэн эрхмүүд байдаг.

ЭШТ Урлагийн бүтээлд

ТРИЗ-д бид Эцсийн Төгс Шийдэл – ЭТШ гэж үзсэн. Техник технологи, шинжлэх ухааны салбарт ЭШТ гэдэг нь техник буюу систем өөрөө биет зүйл, төхөөрөмж хэрэгслийн хувьд Тэг рүү (0- ноль, zero) рүү тэмүүлж, түүний хийх үйлдэл, гүйцэтгэх үүрэг нь 100%- рүү тэмүүлнэ гэсэн үг л дээ. Үр дүнд нь ашигт ажиллагаа

буюу системийн бүтээмж хязгааргүйд тэмүүлнэ. Тиймдээ л Төгс (идеал) гэж нэрлэсэн байж таарна.

Тодорхой жишээ гэвэл, гар утас байна. Анхны телефон утаснууд ямар байлаа, одоо ямар болов? Систем өөрөө тэг рүү тэмүүлж байгаа нь энэ. Залгагчаар холбуулан байж зөвхөн ярьдаг байсан утас өнөөдөр юу хийж байна? Бидний гар утсанд хийхгүй юм гэж байна уу? Ажил үйлдэл нь өдөр ирэх тутам 100%-д ойртоод байгаа биз! ТРИЗ-ээр зэвсэглэсэн хүн ажил үйлсдээ, амьдралдаа чухам үүнд хүрэхийг тэмүүлнэ. Төгс гэсэн үг, ойлголт нь дээд хязгаар, абсолют, хүрэх боломжгүй гэсэн үг байх. Гэхдээ хязгааргүй зүйлд хязгааргүй тэмүүлэх боломж бий. Математикт $\lim: 1, 2$ -р гайхамшигт хязгаар, хязгааргүй дөхөлт гэсэн ойлголт байдгийг бид мэднэ шүү дээ.




Тэгвэл утга зохиол, урлагт ЭТШ гэсэн нэр томъёо, ойлголтыг шууд авч хэрэглэх хэцүү. Урлагийн бүтээлийн ЭТШ гэж чухам юу байж болох вэ? Инженер, эсвэл зохион бүтээгч хүн өөрийн бүтээлийн ЭТШ-ийг тов тодорхой төсөөлж, харж чадаж байхад зураач юм уу хөгжмийн зохиолч тэр болгон тодорхой төсөөлөхгүй. Тэдний хувьд уран бүтээл нь бусдын адил тооцоо төлөвлөгөө, тайлан тайлбартай байх албагүй билээ.

Инженерүүдийн хувьд мэдлэг туршлага, логик сэтгэлгээ, анализ синтез голлох үүрэгтэй байхад, харин зөн билэг, онгод од нь нэмэлт, туслах чанартай. Харин, урлагийнханы хувьд эсрэгээрээ зөн билэг, онгод хамгийн чухал гоо зүйн категори байх жишээтэй. Гэвч урлагийнхны ухааны ур чадвар гайхалтай, инженерийн гэмээр шийдэл гаргах нь цөөнгүй. Ялангуяа тэд өөрийн багаж хэрэгсэл, төхөөрөмжүүдээ сайжруулж шинэчлэхдээ яг л инженер зохион бүтээгч шиг гаргууд сэтгэнэ. Уран бүтээлийн техник технологи гэж бас нэг чухал ойлголт, үйл ажиллагаа бий.


Мольберт, палитр, мастихины шинэ хийц загвар зохиох, холстны шинэ материал, шинэ жаазыг бодон олж, бийрний тусгай харандаа, үс-багс хийсэн нь зураачид өөрсдөө шүү дээ.

Жишээлбэл, Самуэль Морзе

Самуэль Морзе (1791-1872)



Уран зураач, зохион бүтээгч Самуэль Морзе



Мольберт дээрээ бүтээсэн телеграфын аппарат

Самуэль Морзег дэлхий нийгээрээ зохион бүтээгч – инженер гэж боддог. Гэтэл тэр уран зураач хүн байв. Тэрээр харин өөрийн мольбертийг ашиглан телеграфын аппарат гээч цоо шинэ инженерийн бүтээл туурвисан байна. Цахилгаан соронзон бичгийн телеграф ("Морзе аппарат", 1836) ба Морзын үсэг (цагаан толгой) юм.

Урлаг- техникийн уялдаа холбоосын гайхамшиг энэ бус уу?

A ● -	J ● - - -	S ● ● ●
B - ● ● ●	K - ● -	T -
C - ● - ●	L ● - ● ●	U ● ● -
D - ● ●	M - -	V ● ● ● -
E ●	N - ●	W ● - -
F ● ● - ●	O - - -	X - ● ● -
G - - ●	P ● - - ●	Y - ● - -
H ● ● ● ●	Q - - ● -	Z - - ● ●
I ● ●	R ● - ●	

Морзын олон улсын цагаан толгой

3. XIX - XX зууны урлаг дахь этш-ийн жишээ



Италийн зураач Коррадо Кальи



Коррадо Кальи

Коррадо Кальи “үнгэж базсан” цаасны фактур хэмээх санаагаа бүтээл болгон дүрслэх урлагийн хэрэглээнд оруулж ирсэн бөгөөд энэ нь урлаг талаасаа ч, дизайны техник таласаа ч яах аргагүй шинэ бүтээл боловч ТРИЗ-ийн ЭТШ гэж тодорхойлох бараг боломжгүй байгаа юм. Энэ мэтийн судалгааны хүндрэл бэрхшээл захаас аваад зөндөө гардаг.

Үрчгэр цаасны гадаргуу нь үнэхээр хамгийн бага зардлаар дахин давтагдашгүй нэгэн бүтээлийн санааг гаргаж байгаа боловч цэвэр “техникийн гаралтай” ТРИЗ-ийн томъёолол, тодорхойлолтонд нэг л багтахгүй байх жишээтэй. Энэ нь нэг талаас техник, урлаг хоёрын тэс ондоо чанарыг давхар илэрхийлээд байгаа мэт.

Системийн нэгдэл буюу Синтез

Урлагийн янз бүрийн урсгал чиглэлүүдийн синтез гэсэн ойлголт бий. Гэхдээ судлаачид урлагийн ба урлагийн бус салбаруудын нэгдэл-синтезийн талаар өндөр ач холбогдол өгөн ярихгүй л байна.

Энд хэдүүлээ хоорондоо зөрчил бүхий эрс тэс хэд хэдэн дүр дүрслэлийг сентезлэн нэгтгэх замаар шинэ дүрслэл, шинэ санааг гарган авч байгаа жишээ авч үзье. Үүнийг дүрслэх урлагт *агглютинатив* систем буюу үзэгдэл гэж бас нэрлэдэг байна. Энэ нь өөрөөр, нэг үгээр хэлбэл хүний дүр төрхийг амьтныхтай нэгтгэсэн хэлбэрээр илэрдэг. Нэг ёсондоо тэр хоёр дүр төрхийг нийлүүлэн нааж байгаа мэт.

Энэ аргыг эртний болон дундуд зууны үеийн мастерууд цөөнгүй хэрэглэж байсан бол романтизмын үеийнхэнтэй ярих юу байхав.

Нэг жишээ гэвэл Финляндын XX зууны алдарт зураач Хуго Симберг (1873 - 1917)



Хуго Симберг (1873 - 1917) Эгчтэйгээ хамтдаа аз жаргалтай

Тэрээр хүний дүр төрхийг чөтгөрийнхтэй нэгтгэн синтезлээд шинэ дүр төрх бүтээж байжээ. Чөтгөрүүдийн аймшигтай, зэрлэг дүр төрх нь хүнийрхүү болгон “зөөлөрч”, эгээ л хүний хажууд хамтран, зэрэгцэн аж төрөгч болон шинэ шинж

чанартай болж байгаа юм. Чөтгөрүүд бидэнтэй хамт сууж, наадан хөгжиж, тэр ч бүү хэл бяцхан чөтгөр-хүүхдүүдээ хүний хүүхдүүдийн сургуульд явуулна гээч.

Энэ хоёр эрс тэс дүрийг нэгтгэн нэг талаас чөтгөрүүдийг “дээш татан” хүний айдсыг нимгэлнэ. Энэ шинэ шийдэл биш гэж үү? Мөн тэрээр хүний дүр төрхийг бас гэгээлэг, ариун тэнгэрийнхтэй нэгтгэн хүнийг “дээш татна”.



Бүжиг.


Бүжиг бүтэээлд нь чөтгөрүүд эвэртэй, сүүлтэй л болохоос, эгээ л хүн шиг дүрслэгджээ.




Шархадсан Ангел

Шархадсан Ангел. Сэдэв нь гунигтай ч техник, гэрэл сүүдэр нь тайван амгалан бас хүчтэй.

Дараагийн нэг томоохон төлөөлөгч бол Австрийн зураач фантаст Альфред Кубин. Тэрээр амьтан хүний нэгдсэн дүр төрхийг бүтээхдээ тэдний мөн чанар, бас бус чанарыг хооронд нь холин сүлж аймшгийн дүрийг босгохдоо алдартай байж. Энэ мөн л бүтээлч сэтгэлгээний стандарт бус хандлага.



Альфред Кубин (1877 – 1959)



Альфред Кубин. Галзуугийн эрэлд

Түүний зурсан зургууд ихэнх үзэгчдийн гайхшрал, зэвүүцлийг төрүүлдэг бөгөөд Кубины хар бараан авьяас анхнаасаа тэр үеийнхний анхаарлыг татсан байна. “Ницше-гийн номонд солиорсон Климт”, “Австрийн Гойя”-г бүтээж, Гофманы

номонд гайхалтай чимэглэл хийж өгсөн. Тэрээр өөрийн дотоод ертөнцийн дүр төрхийг зургийн цааснаа буулгаж байв.

Альфредийн дотоод ертөнц нь тийм ч баяр баясгалантай биш. Түүнийгээ “Нөгөө тал нь” гэх номондоо бичсэн. Ном нь 52 чимэглэл зурагтай. Эдгээр нь өвөрмөц комиксууд бөгөөд түүний номын бичлэгийн бартаан дундуур уншигчийг гэнэтийн төгсгөл рүү хөтөлнө. Номын жанрыг тэр гээд тодорхойлоход бас л хэцүү. Антиутопи ч юм шиг, гэхдээ л өнгөрсөн зууны эхэн үеийн европын үзэл санааны уур амьсгалыг тусгасан нэлээд нарийн философийн роман.

Энэ ном хэвлэгдээд бүтэн 100 гаруй жил өнгөрч байна. Энэ хугацаанд дэлхийн хоёр дайн болж, өлсгөлөн, геноцид, цөмийн дэлбэрэлтүүд болсон. Альфред Кубины далд ухамсар дэлхийн сүйрлийг зөгнөөд байсан нь түүний номын эхнээс аваад дуустал нэвт шингэсэн харагддаг. Утга зохиолын хувьд ач холбогдол багатай ч энэ зохиол европод их өргөн дэлгэр хүртээл болсны нууц нь чухам үүнд л байх шиг.

70 жилийн өмнө 2-р дайн дууссан боловч дэлхий маань дайны сүйрлийн ирмэг дээр байнга байсаар ирсэн. Тэр нь заавал цөмийн дайн байх ч албагүй. Түүхийн тайз дээр Хүний эрх чөлөө, нандин чанар, сайн сайхны эсрэг өнгөрсөн үеийн аймшигт харгис хий үзэгдэл – сүнсний дайн дэгдсээр байна. Өнөөгийн бидний ийм мэдрэмжүүд “Нөгөө тал” романы гол баатруудынхтай яг ижил байна. Эргэлт буцалтгүй ойртон ирэх аюулын бараан мэдрэмжүүд – энэ л зураач- зөнч Альфред Кубины хүмүүст хүргэх гэсэн мессэж байж. Үүнийгээ ч тэрээр хангалттай хийж чаджээ.

“Демииург двойственен” – “Бүтээгч нэгэн хоёр нүүртэй (талтай)” гэсэн үгээр ном төгсдөг. Шинэ зуун, шинэ эрин биднийг, бидний үр хүүхдийг яаж угтах бол – гэрэлт хорвоогоор уу, үмхий намгаар уу? Хэн ч мэдэхгүй. Альфред Кубин ч 1909 онд бас мэдэхгүй байсан. Гэхдээ түүнээс хойш юу болсныг бид бүгд мэдэж байгаа. Өнөөдрийн гол зорилго бол, өнгөрсний үлэмж хүнд, эргэлтгүй алдааг дахин давталгүй шинэ замаар замнах. Аймшигт харанхуйгаас гэрэл гэгээ рүү, амар амгаланд хүрэх зам.

Альфред Кубин номондоо ч, уран бүтээлдээ ч ирээдүйн дүр төрхийг бусдаас шал өөрөөр бүтээсэн гэмээр байгаа юм. Бидний яриад, түүнд хүрэх гээд байгаа нөгөө дахин давтагдашгүй, бусдаас өөр шинэ санаа, өвөрмөц бүтээл гэдэг чинь энэ л шүү дээ. Үнэхээр сэтгэл зүрх, оюун санааныхаа нэг хэсгийг бүтээл туурвилдаа шингээсэн гэдэг нь яг л энэ байж таарна.

ДААЛГАВАР

1. Альфред Кубиний дотоод ертөнц, онцлог үзэл санаа, түүнийгээ илэрхийлсэн арга зам, арга барил, арга дүрслэлийг тайлбарлалах.

Тайлбар хийхдээ бүтээлч сэтгэлгээний тухайт өөрийн үзэл санаа болон энэ хичээлээс шинээр ойлгож мэдсэн туршилагынхаа үүзнээс тайлбарлан, харьцуулалт хийнэ.

2. Төгсгөлийн хичээлээр хэлэлцэх асуудалд бэлдэх

Хэлэлцэх асуудал:

Өнөөгийн нөхцөлд үүсээд буй “Шинэ хэвийн байдал”-д шилжихэд Урлаг ямар үүрэг оролцоотой байх вэ?

Санал болгох уран бүтээлчид: Өөрсдөө чөлөөтэй сонгож болно

		
Нам Жун Пайк (Nam June Paik)	Хандертвассер (Hundertwasser)	Альфред Кубин (Alfred Kubin)

Ашигласан материал:

1. May & Finch, Implementing, Embedding, and Integrating Practices: An Outline of Normalization Process Theory. 2009
2. Murray et al. (2010) the open book of social innovation
3. "What Is Sustainable & Ethical Fashion?". Sustainable Jungle. Retrieved Oct 6, 2021.
4. "Why Slow Fashion Is The Need Of The Hour". Label. Retrieved October 6, 2021.
5. <https://nafi.ru>
6. <https://ru.wikipedia.org/wiki>
7. <https://karmannoe-zlo.livejournal.com/735053.html>
8. <https://en.unesco.org/news/preparing-youth-new-normal>
9. <https://www.labirint.ru/books/392197/>